

МОНГОЛБАНК-нд

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнийн ажлын тайлан

2024 оны 01 дүгээр улирал

2024 оны 04 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Миний бие П.Мөнх-Эрдэнэ нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Цалин урамшууллын хорооны хурал	Аудитын хорооны хурал	Нийт оролцсон хурал
1.	-	7	1	1	9

Нийт оролцсон 9 удаагийн хурлаар 28 тогтоол шийдвэр гаргасан. Нэг удаад Аудитын хорооны даргын ажлыг түр орлон гүйцэтгэсэн байна.

Хурал хуралдсан огноогоор №2:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Цалин урамшууллын хорооны хурал	Аудитын хорооны хурал
1.	-	2024-01-23 2024-01-26 2024-02-16 2024-02-19 2024-03-01 2024-03-11 2024-03-25	2024-02-27	2024-02-26

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Татгалзсан санал өгсөн асуудал
1.	3	1

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй 3 хэлцэлд оролцож, 1 асуудалд эсрэг байр суурь, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

ТУЗ-ийн дарга, гишүүний хувьд:

1. Хуулийн дагуу санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах ёстой бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд компанийн дүрмийн дагуу ТУЗ-ийн

2. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны хурлаас компанийн хэлбэрийг өөрчлөх, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, холбогдох зөвшөөрлийг Монголбанк, СЗХ-с авч ҮЦТХТ-д бүртгэл хийгдсэн байх тул ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг СЗХ, ҮЦХТ-д тус тус хүргүүлэв.
3. Мөн нэг талаас Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны шийдвэр, нөгөө талаас сайн жишиг тогтоож, хурлыг амжилттай зохион байгуулах үүднээс Компанийн тухай хуулийн хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах, зохион байгуулах заалтыг мөрдлөг болгон санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хуралдуулахаар ТУЗ хурлыг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зарлаж хэлэлцэх асуудлыг батлав.
 1. “Ариг банк” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Их Хуралдай Бизнес төв, 14-р давхрын Ариг банкны төв байрны хурлын танхимд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2.1. Банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах;
 - 2.2. Аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг сонсож, төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.3. Ариг банкны 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг эцэслэн батлах;
 - 2.4. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэлт өгөх;
 - 2.5. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг батлах тухай;
4. Хурлын зарыг банкны веб хуудас болон өдөр тутмын 2 сонин хэвлэлээр нийтэд хүргэсэн ба 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар Банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх тайланг хэлэлцэж дүгнэлт өгөв. Мөн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.
5. Банкны дунд хугацааны 2025-2027 оны стратеги төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар улирал гэхэд ТУЗ-р батлуулах үүргийг Гүйцэтгэх удирдлагад өгөв.
6. ТУЗ-ийн хурал даргалах явцад гишүүд саналыг харгалзан 3 удаа ТУЗ-ийн гишүүд, ДАГ, Гүйцэтгэх удирдлагад шууд үүрэг даалгавар өгч ажиллав.
7. Банкны 2024 бүтэц, орон тоо, төсөв төлөвлөгөө батлах ТУЗ-ийн хурлыг 3 удаагийн хурал дамнуулан өргөн хэлэлцүүлэг хийж, сайжруулалт зөвлөмж өгч ажилласнаар 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн батлав.
8. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө”-г баталж, Банкны 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцаж дүгнэлт гаргав. Мөн хурлаар ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж үнэлэлт, дүгнэлт авахаар шийдвэрлэв.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 3 удаагийн хэлцэлд саналаа өгсөн. Санал өгөөгүй хэлцэл байхгүй. Үүнд:

1. Номин Холдинг ХХК-тай банкны “Хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу “Кредит картын үйлчилгээ” бүтээгдэхүүнээр хамтран ажиллахыг дэмжсэн,
2. Голден пропертиз ХХК-тай банкны шинээр нэвтрүүлж буй “Франчайз зээлийн эрх” бүтээгдэхүүнээр хамтран ажиллахыг дэмжсэн,
3. Голден пропертиз ХХК-тай банкны дотоод эх үүсвэрээр орон сум, амины орон сум

Дээрх хэлцлүүд бүгд харьцуулсан судалгаатай ба ямарваа нэг давуу эрх олгоогүй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100%-ийн саналтайгаар шийдвэрлэсэн.

Санал зөрсөн буюу татгалзсан 1 асуудал нь Хувьцаа эзэмшигчдэд банкны 2023 оны ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудал байсан бөгөөд банкнийг тогтвортой хөгжүүлэх, тэлэх, тэлэхэд ихээхэн хөрөнгийн худалдан авалт шаардлагатай, Монголбанкнаас тавьдаг шаардлагыг өндөр түвшинд хангах зэргийг харгалзан үзэж эсрэг санал өгсөн байна.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны хараат бус гишүүний хувьд:

1. Банк санхүүгийн байгууллагын цалингийн өсөлт, харьцуулсан судалгаа, инфляцын түвшин зэргийг харгалзан үзэж банкны ажилтны цалингийн шатлал, зэрэглэлийг шинэчлэн баталж нийт банкны хэмжээнд цалинг дунджаар 36%-иар өсгөхийг дэмжиж ТУЗ-р батлуулав.

ТУЗ-н хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-н үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дэгийн дагуу, хүчин төгөлдөрт тооцогдох эсэхэд анхаарч ажилдаг.
- Монголбанкнаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг,
- ТУЗ-с засаж залруулах боломжтой асуудлууд байгаа тохиолдолд бид ТУЗ-н түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг өгдөг. Удирдлагын баг эдгээр хүсэлтийг дагаж мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТУЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-с гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс сайтар судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.


ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байна.

Мөн банкны ТУЗ-ийн гишүүдийг чадавхыг үнэлэх зорилгоор **“ТУЗ-ийн гишүүдийн ур чадварын матриц, түүнийг тодорхойлох журам”** баталж холбогдох үүрэг даалгаврыг өгсөн.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн,

Засаглал нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн


П.Мөнх-Эрдэнэ